



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

МАА оны 15 сарын 16 өдөр

Дугаар А/32

Амардалай

Г Өмч хамгаалах байнгын зөвлөлийг Г
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн болон орон нутгийн Өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.7, Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Уугантуяа (Санхүү албаны дарга)
О.Улаанхүү (Төрийн сангийн мэргэжилтэн)
Д.Цэнд-Аюуш (Газрын даамал)
Б.Ууганбаатар (Хэсгийн цагдаа)

Хоёр.Төрийн байгууллагуудын үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавьж, шинээр бүртгэлд авах, данснаас хасах, шилжүүлэх, актлах, устгах үндсэн хөрөнгийн жагсаалтыг үнэн зөв бодитоор гаргуулан холбогдох байгууллагад уламжилж ажиллахыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2020 оны А/45 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880010075